

## ХАРЬЦУУЛСАН ХҮСНЭГТ

№	Үзүүлэлтүүд	Хуучин стандарт	Шинэчилж буй стандарт
1	Стандартын нэр /Монголоор/	<b>Шуудангийн хайрцаг. MNS 5978 : 2014</b>	<b>Шуудангийн хайрцаг. MNS 5978 : 2023</b>
2	Стандартын нэр /Англиар/	Postal box	Postal box
3	Хэрэгцээ шаардлага	.	<p>Монгол Улсын аж ахуйн бүхий л салбарт харилцаа холбоо, мэдээллийн технологийн хэрэглээ өргөнөөр нэвтэрч улс орноо “Цахим Үндэстэн” болох зорилтын хүрээнд өнөөдөр мөрдөгдөж буй стандартыг хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд уялдуулах, мэдээлэл харилцаа холбооны салбарт тус стандартыг мөрдөж буй үйлчилгээний компаниудыг стандарт мөрдөх талаар үнэн зөв мэдээллээр хангах зэрэг шаардлага урган гарсан.</p> <p>Энэхүү стандартуудыг шинэчилснээр харилцаа холбооны талаар гарсан хуулийн нэмэлт өөрчлөлт, бодлогын хүрээнд дээрх стандартыг мөрдөх, МШХХ-ны олон талт цогц үйлчилгээг үзүүлэх боломж өргөжин нэмэгдэнэ.</p>
4	Стандартаар тодорхойлсон үзүүлэлт, шаардлагууд	<ul style="list-style-type: none"> <li>a) Шуудангийн хайрцгийн төрөл</li> <li>b) Шуудангийн хайрцагт тавих ерөнхий шаардлага</li> <li>c) Шуудангийн хайрцгийг үйлдвэрлэх</li> <li>d) Шуудангийн хайрцгийг шалгаж, хүлээн авах</li> <li>e) Шуудангийн хайрцгийг тээвэрлэх</li> <li>f) Шуудангийн хайрцгийг байрлуулах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>a) Шуудангийн хайрцгийн төрөл</li> <li>b) Шуудангийн хайрцагт тавих ерөнхий шаардлага</li> <li>c) Шуудангийн хайрцгийн үйлдвэрлэлд тавих шаардлага</li> <li>d) Шуудангийн хайрцгийг шалгаж, <b>ашиглалтад</b> хүлээн авах</li> <li>e) Шуудангийн хайрцгийг тээвэрлэх</li> <li>f) Шуудангийн хайрцгийг байрлуулах</li> </ul>

5	Норматив эшлэл		<p>Дэлхийн Шуудангийн Байгууллага (UPU)-ын веб хуудас болон дараах эх сурвалжаас эшлэл авсан болно. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. <a href="#">British Standard BS EN13724</a></li> <li>2. <a href="https://www.usps.com">https://www.usps.com</a></li> <li>3. <a href="https://www.safe.co.uk/Categories/us-american-style-mail-boxes">https://www.safe.co.uk/Categories/us-american-style-mail-boxes</a></li> <li>4. <a href="https://heatlieletterboxes.com.au/blogs/heatlie-letterboxes-blog/a-guide-to-letterbox-sizes-locations-and-regulations">https://heatlieletterboxes.com.au/blogs/heatlie-letterboxes-blog/a-guide-to-letterbox-sizes-locations-and-regulations</a></li> <li>5. <a href="https://www.gs1.org/docs/tl/GS1Standards_DeliveryManagement.pdf">https://www.gs1.org/docs/tl/GS1Standards_DeliveryManagement.pdf</a></li> <li>6. <a href="https://digital.gov.ru/ru/documents/">https://digital.gov.ru/ru/documents/</a></li> </ol>
6	Нэр томъёо, тодорхойлолт	<ul style="list-style-type: none"> <li>• <b>3.3 Хаягийн хүргэлтийн буюу орцны хайрцаг</b> Шуудангаар ирсэн илгээмжийг хаягт эзэнд нь хүргэж гардуулах шатан дах аюулгүй байдал, нууц хадгалалтын шаардлагыг хангасан, шуудан холбооны байгууллагаас хэрэглэгчдэд зориулан эзэмшүүлсэн, нийтийн, хувийн эзэмшлийн орон сууц, олон нийтийн болон үйлдвэрийн барилга байгууламжид байрлуулах хайрцаг;</li> <li>• <b>3.4 Электрон (ухаалаг) хайрцаг</b> Шуудангийн байгууллагын илгээмжийн бүртгэлийн системтэй холбогдсон, терминалтайгаа зохицсон программ хангамжтай, мэдрэгчтэй удирдлагын дэлгэцтэй, бүх төрлийн шуудангийн илгээмж багтахуйц, 3 төрлийн хэмжээс бүхий нүдтэй, шуудангийн аюулгүй байдлыг бүрэн хангасан, 24 цагаар ажиллах зориулалттай нийтийн, хувийн эзэмшлийн орон сууц, олон нийтийн болон</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• <b>3.3 Хаягийн хүргэлтийн буюу орцны хайрцаг</b> Шуудангаар ирсэн илгээмжийг хаягт эзэнд нь хүргэж гардуулах шатан дах аюулгүй байдал, нууц хадгалалтын шаардлагыг хангасан, шуудан холбооны байгууллагаас хэрэглэгчдэд зориулан эзэмшүүлсэн, нийтийн, хувийн эзэмшлийн орон сууц, олон нийтийн болон үйлдвэрийн барилга байгууламжид байрлуулах <b>БОЛОМЖТОЙ</b> хайрцаг;</li> <li>• <b>3.4 Электрон (ухаалаг) хайрцаг</b> Шуудангийн байгууллагын илгээмжийн бүртгэлийн системтэй холбогдсон, терминалтайгаа зохицсон программ хангамжтай, мэдрэгчтэй удирдлагын дэлгэцтэй, бүх төрлийн шуудангийн илгээмж багтахуйц, 3 төрлийн хэмжээс бүхий нүдтэй, шуудангийн аюулгүй байдлыг бүрэн хангасан, 24 цагаар ажиллах зориулалттай нийтийн, хувийн эзэмшлийн орон сууц, олон нийтийн болон</li> </ul>

		<p>үйлдвэрийн барилга байгууламжийн дотор болон гадна байрлуулах хайрцаг.</p>	<p>үйлдвэрийн барилга байгууламжийн дотор болон гадна байрлуулах <b>БОЛОМЖТОЙ</b> хайрцаг.</p>
7	<p><b>4. Шуудангийн хайрцагт тавих ерөнхий шаардлага</b></p>	<p><b>4.1.1</b> Захидал цуглуулах хайрцаг нь цэнхэр өнгөтэй байх ба хэлбэр дүрс, овор хэмжээний хувьд тогтоосон хязгаарын дотор ямар ч байж болно.</p> <p><b>4.1.5</b> Захидал цуглуулах хайрцаг нь нүүрэн талдаа захидал хийх зориулалт бүхий гаднын нөлөөллөөс хамгаалах хавхаг буюу хамгаалалт бүхий нарийн цонхтой байх ба уг цонхны урт нь 230 мм (“Шуудангийн дугтуй. Тэмдэглэгээ ба хэмжээ. Техникийн шаардлага MNS 3963:1995” стандартаар тодорхойлсон C5 дугтуй багтахуйц), өргөн нь 5 мм-ээс илүүгүй хэмжээтэй байна.</p> <p>4.4.1 Удирдлагын систем нь мэдрэгч бүхий дэлгэцтэй, нэгдсэн удирдлага бүхий программ хангамжтай, гэрэлтүүлэг сайтай, 1 болон 2 хэмжээст бар код уншигчтай, температур хэмжигч, шошго болон тасалбар хэвлэгчтэй, 24 цагийн хяналтын камертай, дохиоллын системтэй, мөн 3G болон 4G сүлжээнд холбогдон ажиллах боломжтой, байна.</p> <p>4.4.4 Мөн дээр дурдсанаас гадна энэхүү хайрцгийн тасралтгүй үйл ажиллагааг хангахуйц нэмэлт үйлдлүүдийг суурилуулсан байж болно.</p> <p>4.4.5 Программ хангамж нь үйлчлүүлэгчид ашиглахад хялбар, энгийн байх бөгөөд</p>	<p>Хасагдсан.</p> <p><b>4.1.5</b> Захидал цуглуулах хайрцаг нь нүүрэн талдаа захидал хийх зориулалт бүхий гаднын нөлөөллөөс хамгаалах хавхаг буюу хамгаалалт бүхий нарийн цонхтой байх ба уг цонхны урт нь 230 мм (“Шуудангийн дугтуй. Тэмдэглэгээ ба хэмжээ. Техникийн шаардлага MNS 3963:1995” стандартаар тодорхойлсон <b>C4 болон</b> C5 дугтуй багтахуйц), өргөн нь 5 мм-ээс илүүгүй хэмжээтэй байна.</p> <p>4.4.1 Удирдлагын систем нь мэдрэгч бүхий дэлгэцтэй, нэгдсэн <b>удирдлагатай, хайрцаг илгээмжээр ачаалагдах үед эзэмшигчийн утсанд эсхүл мэйл хаягаар мэдээлэл очих</b> программ хангамжтай, гэрэлтүүлэг сайтай, 1 болон 2 хэмжээст бар код уншигчтай, температур хэмжигч, шошго болон тасалбар хэвлэгчтэй, 24 цагийн хяналтын камертай, дохиоллын системтэй байна.</p> <p>4.4.4 Энэхүү хайрцгийн тасралтгүй үйл ажиллагааг хангахуйц нэмэлт үйлдлүүдийг суурилуулсан байж болно.</p> <p><b>4.4.5</b> Программ хангамж нь үйлчлүүлэгчид ашиглахад хялбар, энгийн байх бөгөөд</p>

		Монгол болон Англи хэлний сонголттой байх ёстой.	Монгол болон Англи хэлний сонголттой байна.
8	<b>5. Шуудангийн хайрцгийг үйлдвэрлэх</b>	<b>5. Шуудангийн хайрцгийг үйлдвэрлэх</b>	<b>5. Шуудангийн хайрцгийн үйлдвэрлэлд тавих шаардлага</b>
9	<b>6. Шуудангийн хайрцгийг шалгаж, хүлээн авах</b>	6. Шуудангийн хайрцгийг шалгаж, хүлээн авах 6.1 Шуудангийн хайрцгийг энэ стандартын шаардлагатай нийцүүлэн шалгаж хүлээн авна.	6. Шуудангийн хайрцгийг шалгаж, <b>ашиглалтад</b> хүлээн авах <b>6.1</b> Шуудангийн хайрцгийг энэ стандартын шаардлагатай нийцүүлэн шалгаж <b>ашиглалтад</b> хүлээн авна.
10	Гүйцэтгэл	хэвийн	хэвийн
11	Зохиомж	хэвийн	сайжруулсан
12	Стандарт бичиглэл	хэвийн	сайжруулсан
13	Хуудасны тоо/үндсэн болон хавсралт/	22	20 (нүүр хуудас ороогүй)
14	Бусад		Агуулгын хувьд стандартын 25 хувийг шинэчлэн найруулсан. Хавсралт А дах зургийг хялбаршуулсан.